

1. Нэгдүгээр хэсэг: Палеолит гэж юу гэсэн үг вэ?
А. Хуучин чулуун зэвсэг. В. Дунд чулуун зэвсэг С. Шинэ чулуун зэвсэг D. Плейстоцен
2. Монгол нутагт аль үеэс эртний хүн амьдарч эхэлсэн бэ?
А. Хуучин чулуун зэвсэг В. Дунд чулуун зэвсэг С. Шинэ чулуун зэвсэг D. Хуучин чулуун зэвсгийн доод үеэс
3. Сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр, Хүннүгийн төрийн тэргүүнийг хэн гэдэг байсан бэ?
А. Хагани В. Хаан С. Эзэн D. Шаньюй E. Толгойлогч
4. НТӨ V-IV зуунд Монгол нутагт аль угсаа соёлын нийтлэг бүхий төр улсууд байгуулагдсан байсан бэ?
А. Хүннү, дунху, сянби В. Сянби, жужан, түрэг С. Дунху, сянби, түрэг
D. Хүннү, дунху, юэжи E. Юэжи, дунху, жужан
5. 555 онд Жужан улс мөхсөний дараа түрэгүүдэд шахагдсан жужанчуудын нэгэ хэсэг нь ЭРГҮНЭ ГҮНД, нөгөө хэсэг нь Буйр нуурын сав газар нутаглажээ. Тэгвэл үлдсэн хэсэг нь Түрэг, Уйгурын харьяанд орж, хаана үлдсэн бэ?
А. Бурхан халдунд В. Онон, хэрлэн, туулд С. Гурван голын сав газарт
D. Уугуул нутагтаа E. Цагаан хэрэм орчимоор
6. "... Ийн гарсан монголчуудыг дотор нь Нохос, Хиан хэмээн ангилах бөгөөд нийтэд нь ДАРЛИГИН монголчууд гэдэг байв. Харин хожим нь АЛУН ГОО эхийн гурван хөвүүний удмынхныг НИРУН буюу ариун нуруунаас гарагчид хэмээн нэрлэх болжээ". Эдгээр зүйлс аль бүтээл дээр гардаг вэ?
А. Судрын чуулган В. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх С. Лу Алтан товч
D. Абул Фаражийн түүх E. Агуй үйл хэрэгт агуу удирдлага
7. Хабул хааныг нас барсаны дараа түүнийг орыг Тайчууд овгийн хэн гэдэг хүн залгамжилсан бэ?
А. Амбагай В. Хотула С. Есүхэй D. Бартан E. Тэмүжин
8. Нэгдмэл байдал алдагдаж, дотооддоо зөрчилдөн тэмцэлдэх байсан үеийг Монголын түүхэнд хэрхэн нэрлэдэг вэ?
А. Их Юань улсын үе В. Юань улсын дараах үе С. Их МОГОЛЫн үе
D. Юань улс үргэлжлэн оршсон үе E. Улс төрийн бутралын үе
9. Хятад дахь Монгол Юань улсын ноёрхол эцэс болсоны дараа Хятадад ямар улс байгуулагдсан бэ?
А. Манж В. Мин С. Дайчин улс D. Хожуу Алтан улс E. Цинь улс
10. Баруун гарыг хэн захирах вэ?
А. Хаан В. Хатан С. Түшмэл D. Жонон E. Тайш
11. Ховт аймгийн Хойд цэнхэрийн агуй, Ишгэн толгой, Чандмань хар үзүүр, Увс аймгийн Хад үзүүрт гэх мэт дурсгалт газруудыг багцалвал юуны тухай өгүүлж байна вэ?
А. Хадны зургийн томоохон дурсгал байдаг газрууд
B. Эртний хүмүүс амьдарч байсан газар нутаг
C. Булш оршуулга олддог газар нутаг
D. Буган хөшөө олддог газар нутаг
E. Дөрвөлжин булш олддог газар нутаг
12. Аль суурин нь Монгол нутагт зэс зэвсэг хийж байсныг баталдаг вэ?
А. Дорнод аймгийн Хүйтэнбулаг нуурын неолитын суурин
B. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул
C. Дорнод аймгийн Тамсагбулаг сумын нутаг
D. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндий
E. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагайн агуй
13. Хадны зургийг бүтээсэн аргаар нь хэрхэн ангилдаг вэ?
А. Бодит ба уран В. Зосон ба сийлмэл С. Сийлмэл ба уран D. Зосон ба уран

14. НТӨ IV зуунд Хятадын Жао зэрэг Ванлигууд нүүдэлчдийн морьт цэргийн давуу талыг ойлгож, тэднээс үлгэр аван морьт цэрэг байгуулав. Үүнийг Хятадын түүнэд хэрхэн нэрлэдэг вэ?

- A. Туршлага солилцож суралцсан үе
- B. Хүннүгийн баруун гарыг тасдах бодлого
- C. Нүүдэлчдийн хувцас өмсөж, морин дээрээс харваж намнахыг сурсан үе
- D. Ийм бодлого хэрэгжиж байгаагүй
- E. Зөв хариулт алга

15. НТӨ 198 онд байгуулсан “Энх ургийн гэрээ” хэн гэдэг хааны үед мөрдөх боломжгүй болж ирсэн бэ?

- A. Гүнчэн B. Гаоди C. Түмэн D. Уди E. Гиюй

16. “Хоёр наран ургаваас

Худгийн усан ширгэюү

Хоёр хаан сууваас

Хамаг улсаа барьюу” гэж аль бүтээлд хардаг вэ?

- A. Судрын чуулган
- B. Алтан товч
- C. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх
- D. Монголын нууц товчоо
- E. Агуу үйл хэрэгт агуу удирдлага

17. “Овгоор нүүж буухдаа хүрээ тойрог байрлалаар гэрээ барьж, дундаа овгийн ахлагчийн өргөөг босгон хамгаалж, хамтаараа аж ахуйгаа эрхлэн хөтөлж байсан хэлбэр” аль нь вэ?

- A. Аймаг B. Хүрээ C. Овог D. Сум E. Аравт

18. Ухаант, сэцэн хэмээн алдаршсан хатан хэн бэ?

- A. Сорхогтани B. Самар C. Мандухай D. Хулан E. Өэлүн

19. Монгол улс бүхэлдээ Даян хааны захиргаанд дор нэгдэж Хямрал, тэмцэл нэг хэсэгтээ зогссон тэр үеийг сурвалж бичгүүдэд хэрхэн нэрлэдэг вэ?

- A. Улс төрийн бутралын үе
- B. Гар газар, хөл хөсөр болов
- C. Даян хааны үе
- D. Намжимал үе
- E. Бага хаадын үе

20. 1648 онд Зая бандида Намхайжамц аль үсгийг зохиосон бэ?

- A. Тод үсэг B. Соёмбо үсэг C. Али гали D. Кирилл E. Латин

21. Энэ нь монгол нутгаас 1200 орчим олдсон бөгөөд хамгийн том нь 4 м өндөртэй зүйл юм.

- A. Дөрвөлжин булш B. Хиргисүүр C. Буган хөшөө

22. 2006 онд олон улсын судалгааны баг Алтайн нурууны Мөнх цэдвэгт өндөрлөгөс НТӨ IV-III зууны үеийн эрэгтэй хүний булшийг олсон ба цэвдгийн улмаас зандашсан ажээ. Энэ булш аль аймгийн аль нутгаас олсон бэ?

- A. Баян-Өлгий, Улаанхус
- B. Ховд, Чандмань
- C. Увс, Чандмань
- D. Өмнөговь, Гурвансайхан
- E. Дорнод, Тамсагбулаг

23. Уди хаан Хүннү ба баруун зүгийн улсуудын харилцааг таслах бодлого явуулжээ. Энэ бодлогыг сурвалж бичгүүдэд юу гэж нэрлэж бичсэн байдаг вэ?

- A. Туршлага солилцож суралцсан үе
- B. Хүннүгийн баруун гарыг тасдах бодлого
- C. Нүүдэлчдийн хувцас өмсөж, морин дээрээс харваж намнахыг сурсан үе

D. Ийм бодлого хэрэгжиж байгаагүй

E. Зөв хариулт алга

24. НТӨ IV зуунд Хятадын Жао зэрэг Ванлигууд нүүдэлчдийн морьт цэргийн давуу талыг ойлгож, тэднээс үлгэр аван морьт цэрэг байгуулав. Үүнийг Хятадын түүнэд хэрхэн нэрлэдэг вэ?

A. Туршлага солилцож суралцсан үе B. Хүннүгийн баруун гарыг тасдах бодлого

C. Нүүдэлчдийн хувцас өмсөж, морин дээрээс харваж намнахыг сурсан үе

D. Ийм бодлого хэрэгжиж байгаагүй E. Зөв хариулт алга

25. Хань улс өнөөгийн Шиньжяны бүсэн байсан улсуудтай хиллэх болсноор тус замд ноёрхохын төлөө Хүннүтэй олон жилийн өрсөлдөөнийг эхлүүлжээ. Хожмын түүхчид энэ замыг хэрхэн нэрлэх болсон бэ?

A. Аян зам B. Их худалдааны зам C. Торгоны зам D. Баруун гарын зам E. Дээрх бүгд зөв

26. Чингис хаан Хорезим улсын зүг хөдлөхдөө мэргэн зөвлөгч Елюй Чуцай, дөрвөн хүүгээ, жанжнуудаас Боорчи, Шихихутуг, Зэв, Сүбээдэй нарыг авч явсан бол ХАТДААС хэнийг нь авч явсан бэ?

A. Бөртэй B. Хулан C. Есүй D. Есүгэн E. Зөв хариулт

27. Одоогоор олдод буй монгол хэл, бичгийн хамгийн анхны дурсгал бөгөөд 1225 онд олдсон агаад түүнд “Чингис хаан Сартуул иргэнийг туульж бууж хамаг Монгол улсын ноёд Буха Сочигайд хурсанд Есүнгэ онтудрун гурван зуун гучин таван алдаст онтудлугаа” хэмээжээ. Энэхүү бичгийн дурсгалыг юу гэдэг вэ?

A. Чингисийн чулууны бичиг

B. Анхны хэл бичгийн дурсгал

C. Есүнгэ мэргэний дурсгал

D. Монгол бичгийн дурсгал

E. Зөв хариулт алга

28. Энэ нь монголчуудын ном хэвлэж байсан арга юм.

A. Урлах B. Эсгэх C. Зорох D. Барлах E. Үйлдэх

29. 1640 оны ИХ ЦААЗ хуулийг хаана баталсан бэ?

A. Тарвагтай уулын Улаан бураа

B. Ширээ цагаан нуурт

C. Тарваган тахын овоо

D. Монгол шарын даваа





E. Хүйтэн оргил

30. Зүүн гарт аль, аль аймгууд багтах вэ?

- A. Халх, Цахар, Урианхай
- B. Халх, Ордос, Юншээбү
- C. Урианхай, Түмэд, Ордос
- D. Ордос, Түмэд, Юншээбү
- E. Халх, Түмэд, Урианхай

Хоёрдугаар хэсэг:

31. Зөв харгалзуулна уу?

1	Ховд аймгийн Буянт сумын нутагт орших Чандмань Хар Үзүүрийн сийлмэл зураг	A	
2	Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндий	B	
3	Ховд аймгийн Манхан сумын нутагт орших Хойд Цэнхэрийн агуй зосон зураг	C	
4	Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагайн агуй	D	



1- 2- 3- 4-

32. Зөв харгалзуулна уу?

- | | | |
|------------------|--------------------|----|
| 1. Доод үе | A. 40,000-12,000 | 1- |
| 2. Дунд үе | B. 800,000-100,000 | 2- |
| 3. Дээд үе | C. 100,000-40,000 | 3- |
| 4. Мезолитийн үе | D. 12,000-8,000 | 4- |

33. Зөв харгазуулна уу?

1	Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Гол мад	A	
2	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Хар салаагаас олдсон	B	

3	Дорнод аймгийн Гурванзагал, Чойбалсан сумдын зааг Хөх нуурын Өгөөмөр	C	
4	Төв аймгийн Борнуур сумын Ноён уул	D	

1- 2- 3- 4-

34. Зөв харгалзуулна уу?

1	Хэнтий аймгийн Баян-Адрага сумын Дуурлиг нарс	A	
2	Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод	B	
3	Төв аймгийн Борнуур сумын Ноён уул	C	
4	Архангай аймгийн Хотонт сумын нутаг	D	

35. Дараах утгуудыг зөв харгалзуулна уу?

1	Алгинч	A	Толгойн туршуул цэргийн удирдагч
2	Тамгач	B	Хязгаарын мужуудад сэргийлэн суух цэргийн удирдагч
3	Даргач	C	Их хаанаас эзлэгдсэн мужуудад томилсон, иргэний удирдагч
4	Захирагч	D	Иргэний захиргааны хэргийг эрхэлсэн албан тушаал

1- 2- 3- 4-

36. Дараах утгыг зөв харгалзуулна уу?

1	Агуу үйл хэрэгт агуу удирдлага	A	Лувсанданзан
2	Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх	B	Грегори Абул Фаражи
3	Алтан товч	C	Ата Малик Жувейни
4	Абул Фаражийн түүх	D	Ибн Биби

1- 2- 3- 4-

37. Юань улс нийт хүн амыг дөрвөн зэрэглэлд хуваажээ. Зөв харгалзуулна уу?

1	Нэгдүгээрт	A	Монгол хүн
2	Хоёрдугаарт	B	Өнгөт нүдтэн хэмээх уйгур, перс, арабууд
3	Гуравдугаарт	C	Умард хятадын зүрчид, хятаныг
4	Дөрөвдүгээрт	D	Нанхиад хүмүүс

1- 2- 3- 4-

38. Зөв харгалзуулна уу?

1	Монгол улсын төв эх нутагтаа шилжив	A	1368
2	Эрдэнэзуу хийдийг байгуулав	B	1586
3	108 боть “Ганжуурыг” орчуулж хэвлэв	C	1620-1629
4	Занабазарыг анхдугаар богдоор өргөмжлөв	D	1639




1- 2- 3- 4-


39. Зөв харгалзуулна уу?

1	Эрдэнийн товч	A	Жамбадорж
2	Болор толь	B	XVII
3	Лувсанданзан	C	Саган сэцэн
4	Түмэдийн Алтан хан	D	Шашны цааз

1- 2- 3- 4

40. Зөв харгалзуулна уу?

1	Түмэдийн Алтан ханыг хатны хамт дүрсэлсэн зураг	A	
2	Мин улс	B	
3	Төвөд улс	C	

4	Оросын хаант улс	D	
---	------------------	---	--

1- 2- 3- 4-